ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Аудитын код: ДАА-2025/7/-НА-СТА-ОНА**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр<br>Утас: 70373089, 99023682<br>Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Батсүрэн<br>Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Шинжлэн магадлахуй ЭЗШ” аудит ХХК<br>Утас: 88114867<br>Цахим хаяг:shinjlenmagadlahui.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................

3. Санхүүгийн тайлангийн тодруулга...................................................................................

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..............................................................................

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..............................................................................

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал......................................................................

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..........

4. Аудитын тайлан..............................................................................................................

4.1 Ерөнхий зүйл ...................................................................................................................

4.2 Материаллаг байдал .......................................................................................................

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.........................................................................

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .........

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..................................

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .........................................................................

5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл........................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 165

танай ______________-ны №______________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН АХМАДЫН
ХОРООНЫ ДАРГА П.ЮРА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2024 оны нийт зардлын гүйцэтгэлийн 72 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 10,1 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 17,9 хувийг бусад зардал эзэлж байна.

**Аудитын гол асуудал**

Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2024 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

4525020231

**Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Ахмадын хороо нь 2024 оны төлөвлөгөөнд 1 зорилт, 5 чиглэлийн хүрээнд 32 ажил төлөвлөж 87,5 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**СТ-1А**

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,458,699.60** | **21,102,421.27** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **27,265,074.60** | **12,629,796.27** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **27,265,074.60** | **12,629,796.27** |
| **3121** | **Төгрөг** | **27,265,074.60** | **12,629,796.27** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 27,265,074.60 | 12,629,796.27 |
| **33** | **АВЛАГА** | **677,096.00** | **-** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 89,596.00 | - |
| **335** | **Бусад авлага** | **587,500.00** | **-** |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 587,500.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6,516,529.00** | **8,472,625.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **6,516,529.00** | **8,472,625.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 420,980.00 | 1,897,880.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,561,149.00 | 1,758,749.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | - | 281,596.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,534,400.00 | 4,534,400.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **779,696,914.07** | **759,218,546.01** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **779,696,914.07** | **759,218,546.01** |
| **392** | **Биет хөрөнгө** | **676,781,714.07** | **656,719,346.01** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 721,494,252.35 | 721,494,252.35 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (83,722,407.54) | (101,420,363.82) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 6,500,000.00 | 6,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (2,776,041.53) | (3,588,541.49) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21,648,563.94 | 21,648,563.94 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (13,345,729.05) | (16,815,976.55) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,442,320.00 | 41,942,320.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,751,069.98) | (22,800,225.86) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 27,773,262.02 | 27,773,262.02 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (15,481,436.14) | (18,013,944.58) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **102,915,200.00** | **102,499,200.00** |
| 39301 | Програм хангамж | 2,155,000.00 | 2,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (923,000.00) | (1,339,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 101,683,200.00 | 101,683,200.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **814,155,613.67** | **780,320,967.28** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **400,000.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **400,000.00** | **-** |
| **413** | **Өглөг** | **400,000.00** | **-** |
| **4136** | **Бусад өглөг** | **400,000.00** | **-** |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 400,000.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **813,755,613.67** | **780,320,967.28** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **813,755,613.67** | **780,320,967.28** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **855,884,442.43** | **855,884,442.43** |
| 51101 | Өмч: - төрийн | 716,574,957.43 | 716,574,957.43 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 139,309,485.00 | 139,309,485.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(142,090,569.30)** | **(175,525,215.69)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (128,421,033.03) | (142,090,569.30) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (13,669,536.27) | (33,434,646.39) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 99,961,740.54 | 99,961,740.54 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **814,155,613.67** | **780,320,967.28** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **379,027,500.00** | **383,534,710.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **379,027,500.00** | **383,534,710.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **379,027,500.00** | **383,534,710.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 333,698,470.00 | 338,855,560.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,151,470.00 | 28,326,660.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 315,547,000.00 | 310,528,900.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 45,329,030.00 | 44,679,150.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **392,697,036.27** | **416,969,356.39** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **392,697,036.27** | **416,969,356.39** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **387,943,536.27** | **411,984,356.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **233,127,967.00** | **270,121,272.00** |
| 210101 | Үндсэн цалин | 174,051,669.00 | 211,079,522.00 |
| 210104 | Урамшуулал | 33,600,000.00 | 34,800,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,476,298.00 | 24,241,750.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **26,032,159.23** | **16,617,221.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,398,390.94 | 10,156,484.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,164,519.00 | 2,346,792.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,678,813.00 | 1,417,597.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 70,015.00 | 152,070.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,720,421.29 | 2,544,278.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,326,236.71** | **36,734,163.66** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,520,991.85 | 6,596,133.20 |
| 210302 | Түлш, халаалт | 24,410,898.64 | 25,040,534.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,394,346.22 | 4,797,495.54 |
| 210304 | Байрны түрээс | - | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,789,214.00** | **14,328,210.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 301,600.00 | 687,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 617,424.00 | 265,804.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 859,810.00 | 1,431,454.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 648,000.00 | 378,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 670,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 551,500.00 | 1,555,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,140,880.00 | 10,009,452.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **671,000.00** | **2,078,800.00** |
| 210604 | Урсгал засвар | 671,000.00 | 2,078,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **2,543,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 2,543,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,329,982.00** | **3,323,545.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 111,060.00 | 1,466,980.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648,000.00 | 648,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,500.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 466,000.00 | 370,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 835,622.00 | 629,465.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 184,800.00 | 209,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **77,666,977.33** | **66,238,144.06** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,196,122.00 | 38,259,776.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,470,855.33 | 27,978,368.06 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,753,500.00** | **4,985,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,753,500.00** | **4,985,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,753,500.00 | 4,985,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(13,669,536.27)** | **(33,434,646.39)** |
| **225005** | **Үнэ төлбөргүй гарсан зардал** | | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(13,669,536.27)** | **(33,434,646.39)** |

CT-3A

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **378,440,000.00** | **384,122,210.00** |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **378,440,000.00** | **384,122,210.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **378,440,000.00** | **384,122,210.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **378,440,000.00** | **384,122,210.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 333,698,470.00 | 338,855,560.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,151,470.00 | 28,326,660.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 315,547,000.00 | 310,528,900.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 44,741,530.00 | 45,266,650.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **360,215,152.94** | **398,757,488.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **360,215,152.94** | **398,757,488.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **355,610,152.94** | **393,149,488.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **233,217,563.00** | **270,031,676.00** |
| 210101 | Үндсэн цалин | 174,051,669.00 | 211,079,522.00 |
| 210104 | Урамшуулал | 33,600,000.00 | 34,800,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 25,565,894.00 | 24,152,154.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **26,032,159.23** | **16,617,221.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,398,390.94 | 10,156,484.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,164,519.00 | 2,346,792.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,678,813.00 | 1,417,597.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 70,015.00 | 152,070.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,720,421.29 | 2,544,278.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **36,326,236.71** | **36,734,163.66** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,520,991.85 | 6,596,133.20 |
| 210302 | Түлш, халаалт | 24,410,898.64 | 25,040,534.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,394,346.22 | 4,797,495.54 |
| 210304 | Байрны түрээс | - | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,571,385.00** | **14,204,906.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 258,500.00 | 350,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 570,000.00 | 597,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 859,810.00 | 1,431,454.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 648,000.00 | 378,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,094,195.00 | 1,438,200.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,140,880.00 | 10,009,452.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **8,912,000.00** |
| 210602 | Тавилга | - | 7,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,412,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **2,543,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 2,543,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,999,982.00** | **3,484,545.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 781,060.00 | 1,627,980.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648,000.00 | 648,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,500.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 466,000.00 | 370,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 835,622.00 | 629,465.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 184,800.00 | 209,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **45,462,827.00** | **40,621,976.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,462,827.00 | 40,621,976.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,605,000.00** | **5,608,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,605,000.00** | **5,608,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,605,000.00 | 5,608,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,224,847.06** | **(14,635,278.33)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **18,224,847.06** | **(14,635,278.33)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **9,040,227.54** | **27,265,074.60** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **27,265,074.60** | **12,629,796.27** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 855,523,242.43 | 99,961,740.54 | (128,421,033.03) | 827,063,949.94 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (24,029,013.84) | (24,029,013.84) |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 855,523,242.43 | 99,961,740.54 | (152,450,046.87) | 803,034,936.10 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (13,669,536.27) | (13,669,536.27) |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 855,884,442.43 | 99,961,740.54 | (142,090,569.30) | 813,755,613.67 |
| D01 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 855,884,442.43 | 99,961,740.54 | (142,090,569.30) | 813,755,613.67 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 855,884,442.43 | 99,961,740.54 | (142,090,569.30) | 813,755,613.67 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (33,434,646.39) | (33,434,646.39) |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 855,884,442.43 | 99,961,740.54 | (175,525,215.69) | 780,320,967.28 |

ТГ

## 2.5 Аудит хийсэн зардлын гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 358,364,900.00 | 363,810,428.33 | 5,445,528.33 | 101.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 358,364,900.00 | 363,810,428.33 | 5,445,528.33 | 101.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 355,364,900.00 | 358,202,428.33 | 2,837,528.33 | 100.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279,003,900.00 | 270,031,676.00 | (8,972,224.00) | 96.8 |
| 210101 | Үндсэн цалин | 214,563,900.00 | 211,079,522.00 | (3,484,378.00) | 98.4 |
| 210104 | Урамшуулал | 34,800,000.00 | 34,800,000.00 | - | 100.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 29,640,000.00 | 24,152,154.00 | (5,487,846.00) | 81.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,377,500.00 | 16,617,221.67 | (13,760,278.33) | 54.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,352,500.00 | 15,150,140.67 | (9,202,359.33) | 62.2 |
| 210205 | Элүүл мэндийн даатгал | 6,025,000.00 | 1,467,081.00 | (4,557,919.00) | 24.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,235,500.00 | 36,734,163.66 | 3,498,663.66 | 110.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,684,400.00 | 6,596,133.20 | 911,733.20 | 116.0 |
| 210302 | Түлш, халаалт | 22,795,500.00 | 25,040,534.92 | 2,245,034.92 | 109.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,755,600.00 | 4,797,495.54 | 41,895.54 | 100.9 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 300,000.00 | 300,000.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,348,000.00 | 14,204,906.00 | 5,856,906.00 | 170.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 638,000.00 | 350,400.00 | (287,600.00) | 54.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 597,400.00 | (402,600.00) | 59.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 1,431,454.00 | (68,546.00) | 95.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 378,000.00 | (122,000.00) | 75.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,500,000.00 | 1,438,200.00 | (61,800.00) | 95.9 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 3,210,000.00 | 10,009,452.00 | 6,799,452.00 | 311.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 1.412,000.00 | (588,000.00) | 70.6 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,412,000.00 | (588,000.00) | 70.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 400,000.00 | 2,543,000.00 | 2,143,000.00 | 635.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 400,000.00 | 2,543,000.00 | 2,143,000.00 | 635.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,000,000.00 | 3,484,545.00 | 1,484,545.00 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 870,500.00 | 1,627,980.00 | 757,480.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 648,000.00 | 148,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 370,000.00 | 370,000.00 | |
| 210807 | Газрын төлбөр | 629,500.00 | 629,465.00 | (35.00) | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 209,100.00 | 209,100.00 | |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 13,174,916.00 | 13,174,916.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 13,174,916.00 | 13,174,916.00 | |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,000,000.00 | 5,608,000.00 | 2,608,000.00 | 186.9 |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 3,000,000.00 | 5,608,000.00 | 2,608,000.00 | 186.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 5,608,000.00 | 2,608,000.00 | 186.9 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 358,364,900.00 | 349,175,150.00 | (9,189,750.00) | 97.4 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 297,171,900.0 | 297,171,900.00 | - | 100.0 |
| **120004** | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 61,193,000.00 | 52,003,250.00 | (9,189,750.00) | 85.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,560,000.00 | 6,736,600.00 | (6,823,400.00) | 49.7 |
| 120005 | Түрээсийн орлого | 47,633,000.00 | 45,266,650.00 | (2,366,350.00) | 95.0 |
| **4** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 27,265,074.60 | 27,265,074.60 | |
| **5** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 12,629,796.27 | 12,629,796.27 | |
| **62** | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 24.00 | 23.00 | - | 95.8 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 | - | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | - | 100 |
| 620004 | Гэрээт ажилтан | 14.00 | 13.00 | (1.00) | 92.9 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй**

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Ахмадын хороо нь аймгийн нийт ахмад настнуудын нийтлэг эрх ашиг, эрүүл мэнд, аятай тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах, Ахмад настны тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан төр, засгийн хууль, тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтэд хяналт тавихын зэрэгцээ орон нутгийн төр, захиргаа болон холбогдох дээд шатны байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх, ахмад настны тэтгэвэр, тэтгэмж, халамж, хөнгөлөлт, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлт, хамтын хүчээ хорших замаар өрхийн орлогоо нэмэгдүүлэх дэмжлэг үзүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэлийг “Нийт ахмад настнуудыг нийгмийн халамж болон нийгмийн хамгааллалтын хуульд нийцүүлэн эрх ашгийг нь хамгаалах, оролцуулах” гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 10,11 дүгээр хавсралтын дагуу цалинд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт,шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ахмадын хорооны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ахмадын хорооны 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУЗГ-ын тогтоолын бодлогод МУЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,8 сая төгрөгөөр буюу 4,2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 27,265.1 | 12,629.8 | (14,635.3) |
| Авлага | 677.1 | - | (677.1) |
| Бараа материал | 6,516.5 | 8,472.6 | 1,956.1 |
| Үндсэн хөрөнгө | 779,696.9 | 759,218.6 | (20,478.3) |
| **Нийт хөрөнгө** | **814,155.6** | **780,321.0** | **(33,834.6)** |
| Өр төлбөр | 400.0 | - | (400.0) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 813,755.6 | 780,321.0 | **(33,434.6)** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **814,155.6** | **780,321.0** | **(33,834.6)** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 12,629.8 мянган төгрөг болж 14,635,3 мянган төгрөгөөр буурсан нь Байгаль орчныг хамгаалах төслийн урьд оны үлдэгдэл 2,800.0 мянган төгрөг зарцуулсан, 7,500.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан, 1,900.0 мянган төгрөгөөр аж ахуйн материал худалдан авсан, мөн албан томилолтын зардал нэмэгдсэн зэргээс шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл677.1 мянган төгрөгөөр буурсан нь Замчин худалдааны төвийн түрээслэгчдийн түрээсийн авлагыг барагдуулсан холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,472.6 мянган төгрөг болж 1,956.1 мянган төгрөгөөр өссөн нь "Хүндэт ахмад" тэмдэг 3,955.0 мянган төгрөгөөр худалдан авч бүрэн зарцуулагдаагүй буюу шагнал олгоогүйгээс шалтгаалсан.

Үндсэн хөрөнгийн данс 759,218.6 мянган төгрөг болж 20,478.3 мянган төгрөгөөр буурсан нь 7,500.0 мянган төгрөгөөр ахмадын чийрэгжүүлэлтийн ор худалдан авч үндсэн хөрөнгөд бүртгэн, тайлант онд 27,978.3 мянган төгрөгөөр элэгдэл байгуулж, зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 400,0 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүмүүст төлөх өглөгийг барагдуулсантай холбоотой.

Эзний өмч Засгийн газрын хувь оролцооны дүн 33,434.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зкүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Зардлын төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 299,494.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаар зардлыг 273,856.8 мянган төгрөгөөр баталсан байна. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 03 сарын 27 -ны өдрийн 128-р тогтоолын дагуу цалин нэмэгдүүлэхэд төсвийн тодотголоор 23,315.1 мянган төгрөгний санхүүжилт нэмж олгосон байна.

#### 3.5.2 Зардлын гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 23,315.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 297171,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, өөрийн орлогоос 61193,0 мянган төгрөг, нийт 358364,9 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 297171,9 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн орлого 6736,6 мянган төгрөг, Замчин худалдааны төвийн түрээсийн орлого 45266,6 мянган төгрөг, нийт 349175,2 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 363,810,4 мянган төгрөг буюу 101,5 хувьтай байгаа Гэр бүл, бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Дархан-Уул аймгийн ЗДТГ, Монголын ахмадын холбооноос хамтран зохион байгуулж буй “Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг Дархан-Уул аймагт 2024 оны 11-р сарын 11-12 өдрүүдэд зохион байгуулагдаж Тус сургалтын зардалд 3872,5 мянган төгрөг, Улаан үд хотод Ахмад настны зөвлөгөөнд 2 хүн оролцоход 1413,8 мянган төгрөгний зардал гарсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 72208-Ахмад настны хөгжил хамгаалал: 80404- Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 358,364.9 | 363,810.4 | 5,445.5 | 101.5 |

Зардлын төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3. нэмэлт төсөв

Нэмэлт төсөв байхгүй

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

" Монголын эмэгтэйчүүдийн сан" -ээс Байгаль хамгаалах төсөл хэрэгжүүлсэн. Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хөтөлбөрийн 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль хамгаалах | 2024.12.31 | | 100 | 12,240.1 | 9,370.2 |

### 3.5.5 Худалдан авах ажиллагаа

Ахмадын хороо нь Орон нутгийн өмчийн газарт худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг хүргүүлж, цахим системд 7 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний урсгал зардлыг 8,900.0 мянган төгрөгөөр шууд худалдан авах төлөвлөгөөг мэдээлсэн. 2024 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг худалдан авах ажиллагааны цахим системээр илгээсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Ахмадын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зардлын гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ" аудит ХХК-ийн аудитор Магсаржалам гүйцэтгэж , чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн ахмадын хороо нь 2024 оны санхүүгийн тайлан, зардлын гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ" аудит ХХК-д 2025 оны 02 дугээр сарын 25-ны өдрийн 47 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлын 392,697.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,853.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ахмадын хороо нь тээвэр шатахуун, урсгал засварын зардал, мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнэх, сургалт семинарыг цахимаар зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллээс 4 мэдээлэл оруулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хуулийн хэрэгжилт

Тус байгууллага нь "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байгаа нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолын 1-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар, байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардлыг 50-аас доошгүй хувиар бууруулж, албан ёсны лиценз бүхий баримт бичиг боловсруулах программ хангамж ашиглах арга хэмжээ хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, шүүх,прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад зөвшөөрсүгэй", Цахим, хөгжил харилцаа холбооны сайдын 2022 оны

А/64 дүгээр тушаалаар баталсан "Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Бичиг хэрэг, шуудангийн зардлыг бууруулах зорилгоор албан бичиг солилцооны дундын системийг ашиглах.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,500.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

**5.2 Албан шаардлага**

Тайлант онд албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

**5.3 Зөвлөмж**

5.3. Төлбөрийн баримттай холбоотой асуудал

*5.3.1. Илрүүлэлт*:

Тайлант онд 7,500.0 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д *"Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..."* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*5.3.1. Өгсөн зөвлөмж*:

Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг

дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, төлбөрийн баримтын цахим системд шивэгдээгүй байна. | 1 | 7,500.0 | | | | | 1 | 7,500.0 | | | | |
| **Дүн** | **1** | **7,500.0** | | | | | **1** | **7,500.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2022 оны А/64 дугаар тушаалын дагуу "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байна | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** |

## ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: **Дархан-Уул аймгийн Ахмадын хороо**
Тайлант хугацаа: **2024 он**

*Хүснэгт А. АГАДҮТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх*

/төгрөгөөр/

| № | Нөлөөлж буй АГАДҮТ | АГАДҮТ-ийн дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт: Стандартын заалт | Шалгуур үзүүлэлт: Хууль тогтоомжийн заалт | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Санхүүгийн тайлан | Санхүүгийн тайлантай холбоотой асуудал | Дэлгэрэнгүй бүртгэлээс анхан шатны баримттай тулган баталгаажуулахад7,500,000.0 төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. | 7,500,000.00 | Тийм | Үгүй | НББОУС-1 | Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..." гэсэн заалтыг зөрчсөн байна. | Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал | Зөвлөмж | Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана | | |
| | | | Дүн | 7,500,000.00 | | | | | | | | | |

*Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой биш АГАДҮТ-ыг үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх*

| № | Тодорхойлсон эрсдэл | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт: Стандартын заалт | Шалгуур үзүүлэлт: Хууль тогтоомжийн заалт | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх | Нийтийн мэдээлллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. Монгол Улсын засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалын дагуу "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байна. | | Тийм | Үгүй | НББОУС-1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. Монгол Улсын засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолын 1-д" төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар, байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардлыг 50-аас доошгүй хувиар бууруулж, албан ёсны лиценз бүхий баримт бичиг боловсруулах программ хангамж ашиглах арга хэмжээ хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, шүүх,прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад зөвшөөрсүгэй" Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар баталсан "Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал" | Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал. | Зөвлөмж | Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. | | |
| | | Дүн | | | | | | | | | | |

**Бэлтгэсэн:**
Аудитор — Б.Хоролбат, огноо:

**Хянасан:**
Чанарын хяналтын менежер — Л.Магсаржалам, Огноо:
Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК-ийн захирал — С.Оргил, Огноо:

**Танилцаж, зөвшөөрсөн:**
Дархан-Уул аймгийн Ахмадын хороо
Дарга — П.Юра, Огноо:
Нягтлан бодогч — Д.Оюунчимэг, Огноо: